



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/127/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитор С.Оргил
Утас: 77665858

Цахим хаяг: Shinjenmagadlahui.ezsh.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.25 № 103

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ӨНДӨР-УЛААН
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.БОЛОРМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Өндөр улаан сумын цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 1,437,298.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,305,816.4 мянган төгрөгийг зарцуулан, 142,503.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Өндөр улаан сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	234,413,695.16	212,807,428.02
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	177,794,590.81	142,503,149.02
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	177,794,590.81	142,503,149.02
31210	Төгрөг	177,794,590.81	142,503,149.02
31211	Төрийн сангийн харилцах	177,794,590.81	142,503,149.02
35	БАРАА МАТЕРИАЛ	56,619,104.35	70,304,279.00
35400	Хангамжийн материал	56,619,104.35	70,304,279.00
3541	Бичиг хэргийн материал	363,000.00	-
35420	Аж ахуйн материал	50,154,264.35	70,304,279.00
	Барилгын засварын материал	6,101,840.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	723,254,107.26	708,572,010.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	723,254,107.26	708,572,010.84
39200	Биет хөрөнгө	703,013,907.26	688,631,810.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	573,303,673.12	573,303,673.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	-78,076,711.64	-96,442,651.52
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	92,637,556.70	113,376,102.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-29,437,151.30	-41,219,635.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,492,768.46	73,338,074.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,743,362.77	-27,686,923.81
	Бусад үндсэн хөрөнгө	130,871,233.87	130,271,233.87
	Хуримтлагдсан элэгдэл	-34216,162.02	-42,336,125.25
39217	Ном	4,182,062.84	6,028,062.84
39300	Биет бус хөрөнгө	20,240,200.00	19,940,200.00
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-525,000.00	-825,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	19,265,200.00	19,265,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	957,667,802.42	921,379,438.86
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	957,667,802.42	921,379,438.86
51	Засгийн газрын хувь оролцоо	957,667,802.42	921,379,438.86
51100	Засгийн газрын оруулсан капитал	955,034,746.80	955,034,746.80
	Өмч:- төрийн	955,034,746.80	955,034,746.80
51200	Хуримтлагдсан үр дүн	-84,735,987.41	380,413,063.81
51210	Өмнөх үеийн үр дүн	-84,735,987.41	-121,024,350.97
51220	Тайлант үеийн үр дүн		-36,288,363.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	87,369,043.03	87,369,043.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	957,667,802.42	921,379,438.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,018,426,408.50	1,311,363,785.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,259,308.50	40,836,485.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,259,308.50	40,836,485.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,000.00	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	175,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	22,154,308.00	34,361,485.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	6,300,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	996,167,100.00	1,270,527,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	954,072,100.00	1,208,068,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,208,068,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,095,000.00	62,459,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,095,000.00	62,459,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	868,513,628.04	1,347,652,148.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	868,513,628.04	1,347,652,148.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	850,252,631.78	1,328,060,015.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	557,301,810.00	932,550,695.67
210101	Үндсэн цалин	409,573,395.00	653,275,278.67
210102	Нэмэгдэл	113,005,420.00	207,479,618.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	34,722,995.00	71,795,799.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,718,877.42	115,059,296.12
210201	Тэтгэврийн даатгал	48,948,531.31	79,241,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,551,782.67	9,322,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,441,426.17	4,661,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,067,811.79	4,661,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,709,318.48	17,173,096.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,090,603.74	41,376,667.16
210301	Гэрэл, цахилгаан	9,821,603.74	14,024,267.16
210302	Түлш, халаалт	31,269,000.00	26,839,500.00
210303	Цэвэр, бохир ус		512,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,145,917.80	23,308,215.35
210401	Бичиг хэрэг		363,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	335,755.00	-
210408	Бараа материал акталсны зардал	15,810,162.80	22,945,215.35
2105	Нормативт зардал	100,676,210.00	101,733,650.00
210502	Хоол хүнс	100,676,210.00	101,733,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	17,064,700.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	17,064,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	667,400.00	3,372,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,162,519.77	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,162,529.77	3,372,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,156,693.05	93,594,091.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,559,098.65	29,730,385.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,248,900.00	7,009,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,348,694.40	56,853,756.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,260,996.26	19,592,132.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,151,600.00	19,589,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,151,600.00	19,589,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	109,396.26	2,332.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	109,396.26	2,332.84
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	149,912,780.46	-36,288,363.56
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	149,912,780.46	-36,288,363.56

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	996,272,100.00	1,270,527,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	105,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	105,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	996,167,100.00	1,270,527,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	954,072,100.00	1,208,068,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	954,072,100.00	1,208,068,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,095,000.00	62,459,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байхгууллага/	42,095,000.00	62,459,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	828,423,296.19	1,298,008,566.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	828,423,296.19	1,298,008,566.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	810,162,299.93	1,278,416,433.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	559,109,034.00	932,248,800.00
210101	Үндсэн цалин	378,702,779.00	617,338,460.00
210102	Нэмэгдэл	146,895,083.00	243,114,541.00
210104	Урамшуулал	33,511,172.00	71,795,799.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,911,653.42	115,361,191.79
210201	Тэтгэврийн даатгал	47,579,077.32	79,241,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,439,420.24	9,322,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,351,456.24	4,661,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,046,490.92	4,661,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,495,208.70	17,474,991.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,090,603.74	42,220,167.16
210301	Гэрэл, цахилгаан	8,830,536.74	14,024,267.16
210302	Түлш, халаалт	30,109,000.00	26,839,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,151,067.00	1,356,400.00
2105	Нормативт зардал	100,641,210.00	101,733,650.00
210502	Хоол, хүнс	100,641,210.00	101,733,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	20,236,500.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	20,236,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,396,299.42	3,172,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,396,299.42	3,172,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,013,499.35	63,443,425.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,825,099.35	55,494,125.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,188,400.00	7,949,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,260,996.00	19,592,132.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,151,600.00	19,589,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	18,151,600.00	19,589,800.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	109,396.26	2,332.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	109,396.26	2,332.84
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	167,848,803.81	-27,481,266.79
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,448,100.00	7,810,175.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,448,100.00	7,810,175.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,448,100.00	7,810,175.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	5,448,100.00	7,810,175.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	162,400,703.81	-35,291,441.79
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		177,794,590.81
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	177,794,590.81	142,503,149.02

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	955,034,746.80	87,369,043.03	-121,024,350.56	957,667,802.42
19	Тайлант үеийн үр дүн			-36,288,363.56	-36,288,363.56
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	955,034,746.80	87,369,043.03	121,024,350.97	921,379,438.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү дүн	Харьцуулалт
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,437,298,600.00	1,305,816,408.95	131,482,191.05	90.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,437,298,600.00	1,305,816,408.95	131,482,191.05	90.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,417,708,800.00	1,286,226,608.95	131,482,191.05	90.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,040,987,600.00	932,248,800.00	108,738,800.00	89.6
210101	Үндсэн цалин	700,910,700.00	617,338,460.00	83,572,240.00	88.1
210102	Нэмэгдэл	292,233,300.00	243,114,541.00	49,118,759.00	83.2
210104	Урамшуулал	47,843,600.00	71,795,799.00	-23,952,199.00	150.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,901,700.00	115,361,191.79	5,540,508.21	95.4
210201	Тэтгэврийн даатгал	82,215,400.00	79,241,100.00	2,974,300.00	96.4
210202	Тэтгэмжийн даатгал	9,669,800.00	9,322,500.00	347,300.00	96.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,836,000.00	4,661,300.00	174,700.00	96.4
210204	Ажилгүйдлийн даатгал	4,836,000.00	4,661,300.00	174,700.00	96.4
210205	Эрүүл мэндийн даатгал	19,344,500.00	17,747,991.79	1,596,508.21	91.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,222,500.00	42,220,167.16	2,332.84	100.0
210301	Гэрэл, цахилгаан	13,200,000.00	14,024,267.16	-824,267.16	106.2
210302	Түлш, халаалт	25,962,500.00	26,839,500.00	-877,000.00	103.4
210303	Цэвэр бохир ус	3,060,000.00	1,356,400.00	1,703,600.00	44.3
2105	Нормативт зардал	115,485,100.00	101,733,650.00	13,751,450.00	88.1
210502	Хоол, хүнс	115,485,100.00	101,733,650.00	13,751,450.00	88.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,236,500.00	20,236,500.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	20,236,500.00	20,236,500.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,172,700.00	3,172,700.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,172,700.00	3,172,700.00	0.00	100.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,702,700.00	71,253,600.00	3,449,100.00	95.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,907,400.00	61,458,300.00	3,449,100.00	94.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,795,300.00	9,795,300.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,589,800.00	19,589,800.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,589,800.00	19,589,800.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,589,800.00	19,589,800.00	0.00	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,437,298,600.00	1,270,529,632.84	166,768,967.16	88.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,208,068,300.00	1,208,068,300.00	0.00	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	62,459,000.00	62,461,332.84	-2,332.84	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	62,459,000.00	62,461,332.84	-2,332.84	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	166,771,300.00	0	166,771,300.00	0.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		177,794,590.81	-177,794,590.81	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		142,503,149.02	-142,503,149.02	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	39	39	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	24	24	0.00	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	20	20	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19	19	0.00	100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 209.0 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрсэн бөгөөд 209.0 мянган төгрөгт 1 төлбөрийн акт, 2 зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар илэрсэн зөрчил нь материаллаг бус байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1. Төлбөрийн акт

Тайлант онд өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчийг үндсэн ажилтнаар ажиллуулж, нийт 209.0 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь : Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1. Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон ахуйн хэрэгслийн орлого, зардлын бүртгэл тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан жагсаалтын дагуу эцэг, эх, асран хамгаалагчдаас хүлээн авсныг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалттай нийцэхгүй байна.

Өгссөн зөвлөмж: Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг хүлээн авсан үед бараа материалын зохих дансанд орлогоор, сургалтын үйл ажиллагаанд тавьж олгосон тухай бүр зардлаар бүртгэж бараа материалын тайлан бэлтгэж үр дүнг санхүүгийн тайланд тусгаж, мэдээлэх арга хэмжээ авч ажиллах

3.2.2. Нярвын программ ашиглалт, анхан шатны баримтын боловсруулалт, бараа материалын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн цахим программыг өдөр тутмын ажил гүйлгээнд ашиглаагүй, бараа материалын зарлагын гүйлгээнүүдийг нэгтгэж сарын сүүлийн өдөр программд оруулсан, анхан шатны баримтыг программаар боловсруулаагүй гар аргаар хөтөлсөн байна.

Өгссөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлд нярвын программыг ашиглалтыг сайжруулж бараа материалын гүйлгээг тухай бүртгэх, анхан шатны баримтыг программаар боловсруулж ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "... албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан тул зөвлөмжийн төлөвлөгөөг 2025.03.25-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж ажиллана уу.

Энэхүү зөвлөмжийн төлөвлөгөөг ирүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасан ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг анхааруулна уу.

Зөвлөмжийн биелэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, холбогдох нотлох баримтыг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Цалинтай холбоотой	1	209	-	-	1	209	1						
Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон ахуйн хэрэгслийн орлого, зардлын бүртгэл тайлантай холбоотой асуудал	1						1						
Няrvын программ ашиглалт, анхан шатны баримтын боловсруулалт, бараа материалын тайлантай холбоотой асуудал	1						1						
Нийт дүн	3	209				209	3						